

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОН, НӨХӨН СЭРГЭЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас *Ольгономия* аймаг (хог)-ийн *Ольгономия* сум (дүүрэг)-ын Засаг дарга *Х.Дундговь* (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас "Хуралын хамтгал" хх-ийн нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж *Х.Мунгууруу* (албан тушаал) *Х.Мунгууруу* нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2018 оны 07 сарын сарын 05-ны өдөр энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл


1.1 Бичил уурхай эрхлэгч этгээд нь *Ольгономия* сум (дүүрэг)-ийн *Хуралын хамтгал* гэртэй газарт орших *2.05* гектар талбайд журмын *6.1.3*-т заасны дагуу *2018-10 сар* хугацаагаар (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2.1 Өвөрхангай аймаг Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын тогтоол *...* Газар нутгийг бичил уурхайн зорилуулгаар ашиглах тусгай хэрэгцээнд авсан шийдвэр. Ашигт малтмал газрын тосны 2018 оны 06 сарын 07 өдрийн 7/4213 тоот шийдвэр. Аймгийн засаг даргын 2018 оны 06 сарын 15 ны өдрийн 2/320 тоот шийдвэрийг үндэслэн дор дурдсан салбарт бүхий эзлэгдсэн газрын цэгүүдийг холбосон талбайг бичил уурхай эрхлэгч этгээдэд ашиглуулах.

Цэгийн дугаар	уртраг	өргөрөг
	46.19,48,3	102,31,4.4
	46.19.48	102.31.6.7
	46.19,33,6	102.30,53.8
4	46,19,34,3	102,30,52,2

Бүхнээ 2,05 га талбай



Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2 Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” -ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох.

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг төсцөж, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдэд шаардах,

2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бүс этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх,

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах,

3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах /..... / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх.

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.14. олоорлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хувчлийн этгээдэд худалдах;

3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх;

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

4.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

Гарын үсэг

2019.04.16

2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад эггээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сүм, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана

4.3. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг дарга дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана

Гав. Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1. Энэхүү гэрээ нь 2018 оны 02 сарын 05 өдрөөс 2018 оны 10 сарын 20 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална


Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах


7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно


Гэрээ байгуулсан

 аймаг (хот)-ийн  сум
(дүүрэг)-ын Засаг дарга

 Дашдэлэг

Эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг,
тамга. 

(нөхөрлөл, хоршоо) гөлөөлж

 X Нармандах